



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 05 өдөр

Дугаар А/78

Номгон

Дэд ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд нарын хамтарсан “Нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах тухай” 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн №169, А/698, А/336, А/242 дугаар тушаалыг орон нутагт зохион байгуулах зорилгоор Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3.н, 29.1.6.а, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1, Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.1, Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5 дугаар хэсгийн 5.1.8 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 151 дүгээр тогтоолоор баталсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын 8.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Нөхөн сэргээлт-2024” нэгдсэн арга хэмжээг орон нутагт зохион байгуулах дэд ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Т.Хишигбаатар – Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Нарийн бичиг: Б.Намуун - Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Гишүүд: Д.Сарангарав – Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Б.Оюутболд - Цагдаагийн газрын дарга, Цагдаагийн хурандаа

Н.Бямбадорж - Мэргэжлийн хяналтын газрын дарга

Д.Алтангэрэл – Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга

Э.Ганзориг - Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Б. Алтангадас – Экологийн асуудал хариуцсан эрүүгийн ахлах мөрдөгч

1210181


2.

Сумдын Засаг дарга, Байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч нар

2.Нэгдсэн арга хэмжээг хууль тогтоомжийн дагуу, үр дүнтэй зохион байгуулан эвдэрсэн газрын мэдээлэлд тулгуурлан нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгүүлэх, мэдээллийг сум бүрээр нэгтгэн гаргах, мэдээ тайланг холбогдох газарт хүргүүлэх, цаашид авах арга хэмжээний санал, дүгнэлтийг Засаг даргын зөвлөлд танилцуулахыг ажлын хэсэг /Г.Хишигбаатар /-т даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, уул уурхай, нийгмийн бодлогын асуудал хариуцсан орлогч /Г.Энхбаяр/-т даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН